



МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН
ЧИГЛЭЛД ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025.07.23

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээний
зорилго, үндэслэл, арга зүй**

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх, зохион байгуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Засгийн газарт хэрэгжилтийн явцыг тайлагнах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.1, 18.3, 18.5-д заасны дагуу Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх, мөн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээ бүрээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн маягтын дагуу биелэлтийг гаргаж, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын дагуу new.unelgee.gov.mn цахим програмд үнэлгээг оруулан ажилласан.

**Хоёр. Төлөвлөсөн арга хэмжээний
хэрэгжилтийн явц**

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын

Нэгдүгээр хавсралтаар Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;

Хоёрдугаар хавсралтаар Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр;

Гуравдугаар хавсралтаар Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин;

Дөрөвдүгээр хавсралтаар Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт;

Тавдугаар хавсралтаар Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт;

Зургаадугаар хавсралтаар Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтыг тус тус баталсан.



Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдаагүй тул хавсралт тус бүрээр биелэлтийг гаргаж үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

№	Үзүүлэлт	Нийт заалт	100	99.4	99.3	98	90	83.8	75	70	53.4	50	30	0	Хувь
1	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	17	5				8			3		1			87.06
2	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	9	6		1	1		1							97.9
3	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт	4	2	1							1				88.2
4	Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт	28	13				2			1		3	5		66.07
5	Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт	31	13				1		1	1		2			54.7
	Нийт	89	39	1	1	1	11	1	1	5	1	6	5	0	78.39

Гурав. Дүгнэлт

“Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-ын дагуу Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх 17 арга хэмжээний хэрэгжилтийг 2021-2025 оны хагас жилийн байдлаар авч үзвэл дунджаар **87.06** хувийн биелэлттэй, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт **97.9** хувийн биелэлттэй, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт **88.2** хувийн биелэлттэй, Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгжилт **66.07** хувийн биелэлттэй Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгжилт **54.7** хувийн биелэлттэй тус тус үнэлэгдлээ.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2022, 2023, 2024 оны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, өгсөн зөвлөмжүүдээс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй хэвээр байна. Үүнд:



Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдаагүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг он, оноор тодорхойлоогүй, хариуцах нэгж, байгууллага тодорхойгүй байгаа нь биелэлт авах, үнэлэхэд хүндрэлтэй байгаа тул төлөвлөгөө батлуулж, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хариуцах нэгж, байгууллагыг тодорхой болгохыг Бодлого, төлөвлөлтийн газарт;

Төсөл хэрэгжүүлэх санхүүжилт шийдэгдээгүй, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах санхүүжилт шийдэгдээгүй арга хэмжээнүүдийн санхүүжилтийг тодорхой болгож, үе шаттай шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар болон холбогдох бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад;

Шууд хөрөнгө оруулалт, концессоор хэрэгжүүлж байгаа, өөр яам, байгууллага хариуцан хэрэгжүүлж байгаа учир шийдвэрлэсэн болон зарцуулсан санхүүжилтийн мэдээг гаргах боломжгүй байна гэсэн шалтгаанаар холбогдох маягтын дагуу санхүүжилтийн мэдээ, тайланг бүрэн, үнэн зөв гаргах боломжгүй, цаашид урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээг тайлагнах үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай байна

Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай 28 төсөл, арга хэмжээнээс 18 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн болон хэсэгчлэн шийдвэрлэсэн, 13 төсөл, арга хэмжээний санхүүжилт шийдэгдээгүй байна.

ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай 28 төсөл, арга хэмжээнээс 16 төсөл, арга хэмжээ нь хэрэгжсэн болон боловсруулах шатанд, 12 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төслийг боловсруулаагүй байна.

Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Цаашид урт болон дунд хугацааны бодлогын бичиг баримтуудын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг он, оноор тодорхойлж, хариуцан хэрэгжүүлэх нэгж, байгууллагыг тодорхой зааж, үүрэгжүүлсэн нарийвчилсан төлөвлөгөө гарган жил бүрийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нь тусгуулан ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газарт;

2. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах санхүүжилтийг тодорхой болгож, үе шаттай шийдвэрлүүлэх, санхүүжилтийн мэдээ, тайлан гаргах үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээг авч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар, Төрийн захиргааны удирдлагын газар болон холбогдох бодлого зохицуулалтын газруудад;

3. Бүсийн тээвэр логистикийн төвүүд байгуулах арга хэмжээ, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалтын ажлыг яамд болон зам, тээврийн салбар хоорондын уялдаа холбоог ханган, нэгдсэн



удирдлага зохион байгуулалттай ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газарт тус тус зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР